- Хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;
- Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 онд дэвшүүлсэн зорилго нь “Хүүхэд хөгжлийн жил”, зорилт нь:

- Сумын ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран хүүхэд өсвөр үеийнхнийг гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох сургалт, уулзалт зохион байгуулах
- Бага ангийн сурагчдын дунд “Бид дээрэлхэхгүй” гар зургийн уралдаан зохион байгуулах
- Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сарын аян зохион байгуулах
- Иххэт сум байгуулагдсаны 98 жилийн ойн баярт зориулсан “Наадмын эгшиглэн” тоглолтыг зохион байгуулах
- Улсын Их Хурлын даргын ивээл дор жил бүр орон даяар зохион байгуулагддаг 32 дахь үндэсний “Номын баяр”, Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх
- “Хүүхэд хөгжил 2022” хөтөлбөрийн хүрээнд 9-13 насныханд гар бөмбөгийн спортыг зааж сургах бие бялдрын зөв төлөвшил тогтоох, цагийг зөв боловсон өнгөрөөх зорилготой гар бөмбөгийн дугуйлан хичээллүүлэх
- Монгол ахуйн өв соёл, монгол гэрийн бүтэц, тооно туших зангилаа, шагайн наадгайн төрлүүд)-ийг цэцэрлэгийн бяцхан хүүхдүүдэд заан таниулж сургах сургалт зохион байгуулах
- Үндэсний хөгжмийн дугуйлан хичээллүүлэх
- “1000 төгрөг хүчтэй” аяныг зохион байгуулж хүүхдийн цэцэрлэгт монгол үндэсний тоглоом наадгайтай болгох ажлыг зохион байгуулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллага, сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь , холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,914.3 сая төгрөгөөр буюу 62.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	218,809.50	288,206.00	69,396.50
Авлага	177,112.80	45,688.80	-131,424.00
Бараа материал	389,396.10	64,369.60	-325,026.50
Нөөцийн бараа	9,571.90	12,379.00	2,807.10
Үндсэн хөрөнгө	5,468,353.60	1,938,325.30	-3,530,028.30
Нийт хөрөнгө	6,263,243.90	2,348,968.70	-3,914,275.20
Өр төлбөр	32,692.30	325.10	-32,367.20
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,230,551.60	2,348,643.60	-3,881,908.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,263,243.90	2,348,968.70	-3,914,275.20

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад дансны эцсийн үлдэгдлүүдэд материаллаг өөрчлөлтүүд гарсан бөгөөд улсын төсвийн санхүүжилтийн байгууллага болох эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын төсөв, санхүүгийн тайлан харьяа Төсвийн ерөнхий захирагчдаа шилжиж байгаа нь материаллаг өөрчлөлтүүд гарахад нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 288.2 сая төгрөг болж, өмнөх оноос 69.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	218,809.50	288,206.00	69,396.50
Төгрөг	218,809.50	288,206.00	69,396.50
Төрийн сангийн харилцах	218,808.30	288,206.00	69,397.70
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1.2	-	-1.2
Дүн	218,809.50	288,206.00	69,396.50

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны өөрчлөлтөд: Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 25.1 сая төгрөгөөр, сум хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 54.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, нөхөн сэргээлтийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр, нэмэлт дансны төвлөрүүлэлтийн үлдэгдэл болон ахмадын сангийн зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9.8 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн ба эцсийн үлдэгдэл 288.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 45.7 сая төгрөг болж, өмнөх оноос 131.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	12,969.10	0	-12,969.10
Зээлийн хүүгийн авлага	1,197.10	824.4	-372.70
Байгууллагаас авах авлага	65,662.50	0.00	-65,662.50
Хувь хүмүүсээс авах авлага	97,284.10	44,864.40	-52,419.70
Дүн	177,112.80	45,688.80	-131,424.00

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны өөрчлөлт нь Сум хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл 52.4 сая төгрөгөөр, ЗДТГ-ын авлагын үлдэгдэл 7.2 сая төгрөгөөр, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 71.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Засаг даргын тамгын газар – Завсрын аудитаар тус байгууллагын түрээсийн орлогын төлөвлөгөө 2.0 сая төгрөг ба 9 сарын байдлаар 2.2 сая төгрөгийн орлого төвлөрөхөөр байсан ч тус дүнгээр авлага үүсгээгүй алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар – Завсрын аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд тусгагдсан 0.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 64.4 сая төгрөг болж, өмнөх оноос 325.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	110,306.60	6,100.50	-104,206.10
Тусгай зориулалттай материал	33,668.90	6100.5	-27,568.40
Эм боох материал	76,637.70	0	-76,637.70
Хангамжийн материал	275,684.50	58,269.10	-217,415.40
Бичиг хэргийн материал	21,206.10	4,284.70	-16,921.40
Аж ахуйн материал	214,657.40	46,578.50	-168,078.90
Сэлбэг хэрэгсэл	12942.5	7,405.90	-5,536.60
Түлш, шатах тослох материал	0.20	0.00	-0.20
Хүнсний материал	11,412.50	0	-11,412.50
Бусад хангамжийн материал	15,465.80	0	-15,465.80
Мал амьтад	3,405.00	0.00	-3,405.00
Дүн	389,396.10	64,369.60	-325,026.50

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны өөрчлөлтөд: сумын ИТХ-ын үлдэгдэл 1.2 сая төгрөгөөр, ЗДТГ-ын үлдэгдэл 14.2 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 340.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл хасагдсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал - Тайлант хугацаанд зарцуулсан 4 нэрийн 1.1 сая төгрөгийн бараа материалыг зарлагадаагүй алдааг аудитын явцад залруулав.

3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 12.4 сая төгрөг болж, өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	6,071.90	12,379.00	6,307.10
Бусад нөөц	3,500.00	0	-3,500.00
Дүн	9,571.90	12,379.00	2,807.10

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тэжээлийн нөөцийн дансны үлдэгдэл 2.8 сая төгрөгөөр өссөн нь өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлсэнтэй холбоотой байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,938.3 сая төгрөг болж, өмнөх оноос 3,530.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,328,657.10	1,864,274.70	-3,464,382.40
Барилга, байгууламж, орон сууц	4,353,381.90	1,356,673.80	-2,996,708.10
Авто-тээврийн хэрэгсэл	166,530.00	74,470.50	-92,059.50
Машин тоног төхөөрөмж(компьютер)	239,693.50	56,756.60	-182,936.90
Тавилга, аж ахуйн эд хогшил	103,154.90	37,575.10	-65,579.80
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,736.00	0	-15,736.00
Бусад үндсэн хөрөнгө	407,709.70	338,798.70	-68,911.00
Ном	42,451.10	0	-42,451.10
Биет бус хөрөнгө	139,696.50	74,050.60	-65,645.90
Программ хангамж	4,514.50	1,244.60	-3,269.90
Бусад биет бус хөрөнгө	135,182.00	72,806.00	-62,376.00
Дүн	5,468,353.60	1,938,325.30	-3,530,028.30

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлтөд ЗДТГ-ын хөрөнгө 63.4 сая төгрөгөөр, ИТХ-ын хөрөнгө 3.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 3,596.7 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэл хасагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал – Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл 1.2 сая төгрөг, тайлант хугацааны элэгдлийн зардлыг 0.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар - Завсрын аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд тусгагдсан 13.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар - Завсрын аудитаар санхүүгийн тайланд тусгагдсан 2.5 сая төгрөгийн хөрөнгийг тайлант онд үнэ төлбөргүй авсан орлогоор нэмж бүртгэн давхардуулсан алдааг аудитын явцад залруулав.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 0.3 сая төгрөг болж, өмнөх оноос 32.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	32,692.30	325.10	- 32,367.20
Ажилчидтай холбогдсон өглөг	19,882.70	-	- 19,882.70
Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,008.00	-	- 10,008.00
Байгууллагад төлөх өглөг	34.80	-	- 34.80
Хувь хүмүүст төлөх өглөг	2,766.80	325.10	- 2,441.70
Дүн	32,692.30	325.10	- 32,367.20

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: ЗДТГ-ын өглөг 0.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ, сургууль, цэцэрлэгийн 32.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл хасагдсан нь нөлөөлсөн байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,348.6 сая төгрөг болж, өмнөх оноос 3,881.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,032,553.60	946,290.20	-1,086,263.40
Хуримтлагдсан үр дүн	4,197,998.00	1,402,353.30	-2,795,644.70
Өмнөх үеийн үр дүн	1,997,004.30	4,691,298.60	2,694,294.30
Тайлант үеийн үр дүн	656,013.80	-3,832,179.90	-4,488,193.70
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,544,979.90	543,234.60	-1,001,745.30
Дүн	6,230,551.60	2,348,643.50	-3,881,908.10

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдлийн 1,086.3 сая төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдлийн 1,001.7 сая төгрөгийн бууралтууд нь улсын төсөвт байгууллагуудын оны эхний үлдэгдлийн хасалт байна.

Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 1,402.4 сая төгрөг болж 2,795.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 707.1 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөг, нийт зарлагыг 708.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 129.0 сая төгрөгөөр бууруулж, 579.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 05/04 дугаар тогтоолд зааснаар Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 205.9 сая төгрөгийн

орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан ба үүнийг сумын ИТХ-ын 2021 оны 05/05 дугаар тогтоолоор нэмэгдүүлж, 266.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 09/02 дугаар тогтоолоор сумын татварын болон татварын бус орлогыг 16.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 281.4 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 280.7 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг, өөрийн орлогоор 1.4 сая төгрөг нийт 282.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 0.3 сая төгрөгөөр дутуу буюу 99.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Үйл ажиллагааны орлого	15,211.60	43,651.81	-28,440.21	286.96%
2	Хадгаламжийн хүүгийн орлого	31,826.90	18,819.99	13,006.91	59.13%
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	1,113.10	4,979.15	-3,866.05	447.32%
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	560.00	4,860.00	-4,300.00	867.86%
5	Галт зэвсгийн албан татвар	1,810.00	1,578.00	232.00	87.18%
6	Малын тоо толгойн албан татвар	56,919.60	59,190.30	-2,270.70	103.99%
7	Улсын тэмдэгийн хураамж	1,050.00	1,344.40	-294.40	128.04%
8	Газрын төлбөр	63,499.10	37,372.89	26,126.21	58.86%
9	Хог хаягдлын хураамж	8,111.20	8,652.00	-540.80	106.67%
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал	3,700.00	2,500.00	1,200.00	67.57%
11	Хүү торгуулийн орлого	2,000.00	3,065.00	-1,065.00	153.25%
12	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	5,166.40	1,903.80	3,262.60	36.85%
13	Ан амьтны нөөц ашигласан	31,920.00	0.02	31,919.98	0.00%
14	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	58,543.50	92,750.00	-34,206.50	158.43%
	НИЙТ	281,431.40	280,667.36	764.04	99.73%

Эх сурвалж: Иххэт сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 9 нэр төрлийн орлого 75.4 сая төгрөгөөр давж, 4 нэр төрлийн орлого 43.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлого төлөвлөсөн дүнгээс 34.2 сая төгрөгөөр давсан нь албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн дүнгээс 28.4 сая төгрөгөөр давсан нь арьс шир, ноосны урамшуулал төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 3.9 сая төгрөгөөр давсан нь төсөвт байгууллага бараа, ажил үйлчилгээ худалдан авсантай холбоотой байна.
- Хөрөнгө борлуулсны орлого 4.3 сая төгрөгөөр давсан нь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Нээлттэй хаалганы өдөрлөгийг суманд 2 удаа зохион байгуулж, улсын бүртгэлийн гэрчилгээг газар дээр нь олгосноор тус орлогын гүйцэтгэл өссөн.
- Малын тоо толгойн албан татварын орлого 2.3 сая төгрөгөөр давсан нь татвар төлөгчид татвараа бүрэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Улсын тэмдэгийн хураамжийн орлого 0.3 сая төгрөгөөр давсан нь уул уурхайн аж ахуйн нэгжийн цооног өрөмдлөгтэй холбоотой байна.
- Хог хаягдлын төлбөр 0.5 сая төгрөгөөр давсан нь тус суманд харьяалалтай уул уурхай компаниудаас болон аж ахуйн нэгж, төсөвт байгууллагууд хураамжаа бүрэн төлсөнтэй холбоотой байна.
- Хүү торгуулийн орлого 1.1 сая төгрөгөөр давсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.

- Төсөв байгууллагын өөрийн орлого төлөвлөсөн дүнгээс 0.4 сая төгрөгөөр давсан нь үйл ажиллагааны орлогоос шалтгаалсан байна.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд:

- Хадгаламжийн хүүгийн орлого 13.0 сая төгрөгөөр тасарсан нь Төрийн банкны хадгаламжийн хүүгийн орлого суманд ордоггүй болсонтой холбоотой байна.
- Галт зэвсгийн албан татварын орлого 0.2 сая төгрөгөөр тасарсан нь галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байна.
- Газрын төлбөр 26.1 сая төгрөгөөр тасарсан нь уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөгөөг хэт өндрөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 31.9 сая төгрөгөөр тасарсан нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ан агнах /аргал/ зөвшөөрөл олгоогүйтэй холбоотой байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын 2021 оны 05/05 дугаар тогтоолоор 1,154.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 699.7 сая төгрөгийг урсгал зардалд, 454.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 373.2 сая төгрөгийг аймгаас авах татаас санхүүжилтээс, 266.4 сая төгрөгийг сумын татварын болон татварын бус орлогоос, 158.4 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 356.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 1.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,154.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд төсөвт нэг удаа тодотгол хийсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022 оны 09/02 дугаар тогтоолоор 118.2 сая төгрөгөөр бууруулж 1,036.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгаас авах татаас санхүүжилтийг 134.3 сая төгрөгөөр бууруулж, сумын татварын болон татварын бус орлогыг 15.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсөв зарцуулах эрхийг 1,036.1 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын татварын болон татварын бус орлого 282.1 сая төгрөг, аймгаас авсан татаас санхүүжилт 228.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 356.3 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 55.0 сая төгрөг нийт 922.1 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 842.2 сая төгрөг буюу 81.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 129.1 сая төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 0.3 сая төгрөгөөр, багийн ИНХ-ын даргын урамшууллын зардлыг 0.3 сая төгрөгөөр, ОНХС-ийн зардлыг 64.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл Т
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	510,333.00	381,273.90	129,059.10	74.7%
2	Баг, хорооны ҮАЗардал	40,403.10	40,144.70	258.40	99.4%
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	150.00	150.00	0.00	100.0%
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,400.00	1,388.00	12.00	99.1%
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	10,000.00	9,958.40	41.60	99.6%
6	Хур хог хаягдал, орчны бохирдол	5,500.00	5,500.00	0.00	100.0%
7	Улсын их баяр наадам	5,000.00	5,000.00	0.00	100.0%
8	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	6,673.30	6,338.90	334.40	95.0%

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	2,000.00	1,999.90	0.10	100.0%
10	ОНХС – Бусад хөрөнгө оруулалт	454,657.80	390,419.00	64,238.80	85.9%
	Дүн	1,036,117.20	842,172.80	193,944.40	81.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

2. Аймгийн ИТХ-ын 2021 оны 05/04 дүгээр тогтоолоор сумын Эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Соёлын байгууллагуудын үйлчилгээ ашиглалтын зардлыг 549.3 сая төгрөгөөр, зардлын санхүүжилт 549.3 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгохоор тус тус баталсан байна.

Хүснэгт 12. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын санхүүжилтийн хуваарилалт, төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Соёлын төв	165,789.70	164,115.03	1,674.67	98.99%
2	ЭМТөв	72,355.30	70,289.06	2,066.24	97.14%
3	Сургууль	227,168.30	227,059.07	109.23	99.95%
4	Цэцэрлэг	83,990.10	82,875.42	1,114.68	98.67%
	Дүн	549,303.40	544,338.58	4,964.82	99.10%

Гүйцэтгэлээр 323.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, цалингийн зардалд 39.8 сая, АОНДТШ-ийн зардалд 5.2 сая, тогтмол зардалд 254.5 сая, урсгал засварын зардалд 23.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 13. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,553.60	55,553.25	0.35
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,866.50	6,866.49	0.01
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	461,047.00	457,877.27	3,169.73
4	Урсгал засварын зардал	25,836.30	24,041.57	1,794.73
	Нийт	549,303.40	544,338.58	4,964.82

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

Сумын Засаг даргын тамгын газар – Тайлант оны тусгах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг давхардуулан бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар – Завсрын аудитаар тус байгууллага нь тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа албан хаагчаас тэтгэврийн даатгал суутгасан алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар – Завсрын аудитаар тус байгууллагын дарга тайлант хугацаанд Овооны тахилгад 2 удаа тус бүр 20 л бензин зарцуулж автомашин ашиглаж нийт 40л 0.1 сая төгрөгийн бензин зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын Засаг даргын тамгын газар - Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 324.8 сая төгрөгийн 15 гүйлгээг бүрэн байршуулсан, зарлагын 73.9 сая төгрөгийн 5 ажил гүйлгээнээс 39.3 сая төгрөгийн 5 гүйлгээг байршуулаагүй, өмч хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 15 тушаал шийдвэр гарснаас 4 тушаалыг байршуулаагүй, 6 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсөвт байгууллагууд нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 6.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20.3 сая, нийт 26.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: хангамж, бараа материалын зардалд 1.4 сая, томилолтын зардалд 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 23.0 сая, нийт 24.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн үр ашигтай захиран зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах Б.Алтанзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1.5 хувиар буюу 94.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Учир нь 2022 оноос улсын төсвийн санхүүжилтийн байгууллага болох эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын төсөв, санхүүгийн тайлан харьяа Төсвийн ерөнхий захирагчдаа шилжиж байгаатай холбоотойгоор 2021 оны санхүүгийн тайлангаар материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгох боломжгүй гэж үзлээ.

Гүйцэтгэлээр материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 2,349.0 сая төгрөгийн 1.5 хувь буюу 35.2 сая төгрөг, үүний 70 хувь болох 24.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дараах алдаа зөрчил гарсан байна. Үүнд:

- Сумын Засаг даргын тамгын газар - Завсрын аудитаар тус байгууллагын дарга тайлант хугацаанд Овооны тахилгад 2 удаа тус бүр 20 л бензин зарцуулж автомашин ашиглаж нийт 40л буюу 0.1 сая төгрөгийн бензин зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 357.7 сая төгрөгийн худалдан авалтын санхүүжилтийг, өмч хөрөнгө зарцуулах 481.9 сая төгрөгийн 26 шийдвэрийг хугацаандаа, бүрэн мэдээлсэн байна.

Сумын Засаг даргын тамгын газар - Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 324.8 сая төгрөгийн 15 гүйлгээг бүрэн байршуулсан, зарлагын 73,.9 сая төгрөгийн 5 ажил гүйлгээнээс 39.3 сая төгрөгийн 5 гүйлгээг байршуулаагүй, өмч хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 15 тушаал шийдвэр гарснаас 4 тушаалыг байршуулаагүй, 6 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	-	1	-	100%
Зөвлөмж	1	-	1	-	100%
Нийт дүн	2	-	2	-	100%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага, сан түүврээр хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 1 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6.8 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6.8 сая төгрөгийн алдааг залруулав. Үүнд: Татварын орлогыг татварын нэрийн данснаас сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэхдээ 6.8 сая төгрөгийг татварын нэр зөрүүлэн хаасныг залруулав.

Аудитаар илэрсэн нэг зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын татварын орлого нь 4 нэр төрлийн орлого 43.6 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнд газрын төлбөрийн орлого уул уурхайн компаниудын төлбөр төлөгдөөгүйгээс 26.1 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг үндэслэлгүй төлөвлөснөөс шалтгаалж 1.2 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ан агнах /аргал/ зөвшөөрөл олгоогүйгээс 31.9 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн зардал багасах эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Бүх шатны төсвийн захирагч нь хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг бодитоор төлөвлөх, татварын орлогыг нэр төрлөөр нь төлөвлөгөөний дагуу биелүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	3.0			2	3.0	2	3.0				
Засаг даргын тамгын газар	5	19.1			5	19.1	5	19.1				
Засаг дарга	1	6.8			1	6.8	1	6.8				
Дүн	8	28.9			8	28.9	8	28.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Иргэдийн төлөөлөгчдийн хурал													
Засаг даргын тамгын газар	2	0.8			1	0.6	1	0.2					
Засаг дарга	1	-					1	-					
Дүн	4	0.8			1	0.6	2	0.2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Засаг даргын тамгын газар	1	-							1	-		
Дүн	1	-							1	-		